

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 05 сарын 09 өдөр

Дугаар А/17

Арвайхээр

Эрүүл мэндийн цогц үзлэг зохион байгуулах тухай

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.2.1.4 дэх заалт, Глобаль сан, Монголын сумын эмч мэргэжилтнүүдийн холбоо, Эрүүл мэндийн газартай байгуулсан 2021-2023 онд хамтран ажиллах гурвалсан гэрээг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Уушгины болон уушгины бус эрхтэний сүрьеэ, цусны даралт ихсэх өвчин, чихрийн шижин өвчин, умайн хүзүүний хорт хавдар илрүүлэх эрүүл мэндийн цогц үзлэг, шинжилгээг эрсдэлт бүлгийн хүн амд зохион байгуулах удирдамжийг нэгдүгээр, үзлэг зохион байгуулах календарчилсан төлөвлөгөөг хоёрдугаар, зардлын хуваарийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Шаардлагатай тоног төхөөрөмж, хүний нөөцөөр ханган ажиллуулахыг Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн захирал, Хархорин нэгдсэн эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нарт даалгасугай.

3. Эрүүл мэндийн цогц үзлэгт зарцуулагдах зардлыг зориулалтын дагуу зарцуулахад хяналт тавихыг Ерөнхий санхүүч (Б.Валя), сум, өрхийн эрүүл мэндийн төвийн нягтлан бодогч нарт зөвшөөрсүгэй.

4. Удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн хэлтэс (М.Золзаяа), тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг хяналт-шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтэс (Я.Жаргал)-д тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ШИВААННҮРДЭВ

Эрүүл мэндийн газрын даргын
2022 оны 05 дугаар сарын 09
өдрийн 4/2 дугаар тушаалын
нэгдүгээр хавсралт

ИЮБОНУТ

**СҮРЬЕЭГЭЭР ӨВЧЛӨХ ЭРСДЭЛТ БҮЛГИЙН ХҮН АМД
СҮРЬЕЭ, АРТЕРИЙН ГИПЕРТЕНЗИ, ЧИХРИЙН ШИЖИН,
УМАЙН ХҮЗҮҮНИЙ ХОРТ ХАВДРЫН ЦОГЦ ИЛРҮҮЛЭГ
ҮЗЛЭГИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ**

Үндэслэл:

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын тайлангаар манай улс сүрьеэгийн дарамт өндөртэй 30 орны тоонд орсон бөгөөд жилд 13000 сүрьеэгийн шинэ өвчлөл бүртгэгдэх тооцоолол байгаагаас 30 хувийг илрүүлж, 70 хувийг илрүүлж чадахгүй байна. Монгол улсын 30-аас 70 насны хүн амын дундах зүрх судас, хавдар, чихрийн шижин, амьсгалын замын архаг өвчнөөс шалтгаалсан эрт нас барах магадлал 30.2 хувь байгаа нь дэлхийн дундажаас 11.9, бүсийн дундажаас 14 хувиар тус тус өндөр байна.

2021 онд манай аймаг сүрьеэгийн илрүүлэлтийн дундаж 20.6 хувь байгаа нь улсын дундажаас 0.4 хувь бага, 2019 оны үзүүлэлтээс 10.1, 2020 оноос 6.5 хувиар тус тус буурсан байна.

Халдварт бус өвчний гол шалтгаан болсон артерийн даралт ихсэх өвчин, умайн хүзүүний хавдар, чихрийн шижин өвчнөөс шалтгаалсан эрт нас барах эрсдэл буурч байгаа хэдий ч одоогийн төсөөллөөс харахад 2030 он гэхэд халдварт бус өвчнөөр эрт нас баралтын гуравны нэгээр бууруулах зорилтод хүрэхгүй болох байдал ажиглагдаж байгаа учир энэ чиглэлийн үйл ажиллагааг эрс идэвхжүүлэх хэрэгтэй. 2020 оны байдлаар артерийн даралт ихсэх эрт илрүүлэг өмнөх онтой харьцуулахад 27.6 хувиар буурсан, чихрийн шижин өвчний илрүүлгийн үзлэгт хамрагдвал зохих хүн амын 40.9-хувь, умайн хүзүүний хорт хавдрын илрүүлэгт хамрагдвал зохих эмэгтэйчүүдийн 43.4 хувь нь тус тус хамрагдсан байна.

Сүрьеэгийн илрүүлэлт, халдварт бус өвчний эрт илрүүлгийн бууралт нь өвчтөн тусламж үйлчилгээнээс хожимдох, хүндрэл, нас баралт нэмэгдэх хандлагатай тул иргэдийг сүрьеэ өвчний илрүүлэг үзлэгт өргөн хамруулах, оношилсон тохиолдолд цаг алдалгүй бүрэн эмчлэх, артерийн гипертензи, чихрийн шижин, умайн хүзүүний хорт хавдрын урьдчилан сэргийлэх үзлэгийг сүрьеэгийн илрүүлэг үзлэгтэй хамт үр дүнтэй зохион байгуулах нэн шаардлагатай байна.

Зорилго:

Алслагдсан орон нутгийн зорилтот бүлгийн хүн амыг эрүүл мэндийн цогц үзлэг, шинжилгээнд хамруулж, халдварт болон халдварт бус өвчнийг эрт илрүүлэх, хяналтанд авч эмчлэхэд оршино.

Зорилт:

1. Сүрьеэгээр өвчлөх эрсдэлт бүлгийн хүн амд сүрьеэгийн халдварыг илрүүлэх
2. Артерийн гипертензи, чихрийн шижин, умайн хүзүүний хорт хавдрыг илрүүлэх
3. Илрүүлсэн сүрьеэ, артерийн гипертензи, чихрийн шижин, умайн хүзүүний хорт хавдрын тохиолдлыг оношилгоо, эмчилгээнд бүрэн хамруулах
4. Шийдвэр гаргагч болон ард иргэдийн сүрьеэ болон халдварт бус өвчний талаарх мэдлэг, хандлагыг дээшлүүлэх

Хамрах хүрээ:

Аймгийн хэмжээнд 19 сум, нээлттэй болон хаалттай 2 хорих ангийн сүрьеэгээр өвчлөх эрсдэлт бүлгийн хүн амыг хамруулна.

Дараах бүлгийн иргэдийг сүрьеэгээр өвчлөх эрсдэлт бүлэгт хамруулна. Үүнд:

1. Орон гэргүй, эмзэг, ядуу, амжиргааны түвшин доогуур иргэд,
2. Өмнө нь сүрьеэгийн эмчилгээнд хамрагдаж байсан иргэд,
3. Сүрьеэтэй өвчтөний гэр бүлийн гишүүд болон ойрын хавьтал,
4. ХДХВ-ийн халдвартай болон дархлаа дарангуйлах эмчилгээ хийлгэж байгаа иргэд,
5. Чихрийн шижин өвчтэй, тураалтай, жин багатай, архины хамааралтай иргэд,
6. Ахмад настан,
7. Хоригдол,
8. Сэтгэцийн эмгэгтэй иргэд
9. Алслагдсан сумын иргэд

Хугацаа: 2022 оны 5 дугаар сарын 11-нээс 2022 оны 6 дугаар сарын 21 хүртэл

Зохион байгуулагч: Аймгийн Эрүүл мэндийн газар, Бүсийн оношилгоо эмчилгээний төв

Хамтран зохион байгуулагч: Монголын сумын эмч мэргэжилтнүүдийн холбоо

Санхүүжүүлэгч байгууллага: Глобаль сангийн дэмжлэгтэй сүрьеэгийн төсөл

Хэрэгжүүлэх байгууллага: Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд

Үзлэг хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүн:

Багийн ахлагч: ЭМГ-ын тархвар судлаач эмч

Бүсийн оношилгоо эмчилгээний төв:

- Сүрьеэгийн тасгийн эрхлэгч
- Дүрс оношилгооны эмч
- Дотрын эмч
- Сүрьеэгийн лаборант
- Рентген техникч
- Жолооч -2

Сум, өрхийн эрүүл мэндийн төв:

- Их эмч
- Багийн эмч
- Эх баригч

Хяналт хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүн:

- Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга
- Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн ахлах мэргэжилтэн
- Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн халдварт бус өвчний асуудал хариуцсан мэргэжилтэн

Оролцогч байгууллагын гүйцэтгэх үүрэг, үйл ажиллагааны чиглэл:

1. Эрүүл мэндийн газар:

- Эрсдэлт бүлгийн хүн амыг уушгины болон уушгины бус эрхтэний сүрьеэ, цусны даралт ихсэх өвчин, чихрийн шижин өвчин, умайн хүзүүний хорт

- хавдар илрүүлэх эрүүл мэндийн цогц үзлэг, шинжилгээнд хамруулах ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангах
 - Сүрьеэгийн тусламж үйлчилгээний дэмжлэгт хяналтыг хийж, мэргэжил аргагүйгээр хангах
 - Илрүүлэг үзлэг, шинжилгээнд шаардлагатай маягт, асуумжуудыг олшруулж бэлтгэх
 - Шийдвэр гаргагч болон ард иргэдэд сургалт зохион байгуулах
 - Идэвхтэй илрүүлэлтийн тайланг нэгтгэн Монголын сумын эмч мэргэжилтнүүдийн холбоонд хүргүүлэх
 - Сүрьеэгийн идэвхтэй илрүүлэлтийн тайланд дүн шинжилгээ хийж, эргэн мэдээлэх
2. Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Сүрьеэгийн диспансер:
- Идэвхтэй илрүүлэлтийн талбарын багийг томилж, тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангаж, хамтран ажиллах
 - Идэвхтэй илрүүлэлтийн явцад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж, сүрьеэгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээг үзүүлэх
 - Сүрьеэгийн илрүүлэг үзлэгийг эмнэлзүйн удирдамжийн дагуу хийх
 - Илэрсэн тохиолдлын эмчилгээ, хяналтын асуудлыг Эрүүл мэндийн сайдын “Сүрьеэгийн тусламж үйлчилгээ үзүүлэх журам, заавар”-ыг баримтлан хэрэгжүүлэх
 - Идэвхтэй илрүүлэлтээр илрүүлсэн сүрьеэгийн шинэ тохиолдлыг TUBIS цахим бүртгэлийн системд бүртгэж оруулах
 - Идэвхтэй илрүүлэлтийн тайланг нэгтгэн Эрүүл мэндийн газарт хүргүүлэх
3. Сум, өрхийн эмнэлэг, эрүүл мэндийн төв:
- Илрүүлэг үзлэгт хамруулах эрсдэлт бүлгийн хүн амын судалгааг нэрсээр гаргаж, Эрүүл мэндийн газарт 5 дугаар сарын 10-ны дотор ирүүлэх
 - Үзлэг зохион байгуулахаас 3-5 хоногийн өмнө эрсдэлт бүлэгт үзлэгт хамрагдах зар хүргэх
 - Үзлэг зохион байгуулах өрөө, байрыг бэлтгэж, бэлэн байдлыг хангах
 - Артерийн гипертензи, чихрийн шижин, умайн хүзүүний хорт хавдрыг илрүүлэх үзлэгийг эмнэлзүйн удирдамжийн дагуу хийх
 - Илрүүлэг үзлэгт эрсдэлт бүлгийн 90-ээс доошгүй хувийг хамруулах ажлыг зохион байгуулах
 - Аймгийн ажлын хэсэгтэй хамтран ажиллах эмч, сувилагчийг томилж, ажил үүргийн зохицуулалт хийх

Хамрах хүрээ: Өвөрхангай аймгийн 19 сумын эрсдэлт бүлгийн хүн амыг хамруулна.

Хүлээгдэж буй үр дүн:

1. Орон нутгийн хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмж нэмэгдэнэ.
2. Хүн амын дунд зонхилон тохиолдох сүрьеэ, халдварт бус өвчин, сүрьеэг эрт илрүүлж, халдвар тархах эрсдэлийг бууруулан хүндрэл нас баралтаас сэргийлнэ.
3. Иргэдийн эрүүл мэндийн мэдлэг, хандлага сайжирна.

